

## ИСТОРИЧЕСКИЕ ТРАДИЦИИ ПО ПРИЗНАНИЮ ПОДЖОГА ЛЕСА И СТЕПИ ТЯЖКИМ ПРЕСТУПЛЕНИЕМ В ДРЕВНИХ И СРЕДНЕВЕКОВЫХ СВОДАХ ПРАВА, КОДЕКСАХ И ЗАКОНОДАТЕЛЬНЫХ ИСТОЧНИКАХ

### HISTORIAL TRADITION THAT WAS LEGALIZED THE CRIME KN BIG FIRE ON FOREST, IN WRITINGS ABOUT MONGOLIAN ANCIENT IEGAL SORCE

#### МОНГОЛЫН ЭРТНИЙ ХУУЛЬ ЦААЗЫН СУРВАЛЖ БИЧГҮҮДЭД ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМЭР ТАВИХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ



##### **Б.МАШБАТ**

Заведующий кафедрой по борьбе с пожаром  
Института по чрезвычайной ситуации, полковник

##### **MASHBAT B.**

Head, Faculty of Firefighter Training,  
Institute of Emergency Management, LEU, Emergency Management Colonel

##### **Б.МАШБАТ**

ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх  
албаны тэнхимийн эрхлэгч, докторант, онцгой байдлын хурандаа

**Abstract:** The nature of Mongolia has been kept as a sacred, naturally beautiful and wild for hundreds of years. It is relatively connected to Mongolian ancestors religious contact, tradition culture to a nature, worshipping the land properly.

In the ancient laws of Mongolia, protecting the environment and crime of forest fire were vital provisions.

**Товч агуулга:** Монгол орны байгаль олон зуун жилийн турш онгон сайхнаараа нандигнан хадгалагдаж ирсэн нь өвөг дээдсийн маань эх дэлхий байгальтайгаа зөв зохистой харьцаан, хамгаалж ирсэн уламжлал, ёс заншил, байгаль шим ертөнцөө тахин шүтэж ирсэн зан үйлтэй шууд, холбоотой юм.

Монголчуудын эртний хууль цаазад байгаль орчноо хамгаалах болон ой хээрийн түймэр тавих заалт нь онцгой байрыг эзэлдэг байжээ.

#### Удиртгал

Манай улсад хар тамхи, мансууруулах бодис байнга хэрэглэгч, донтогчдын давхарга бий болсон, хууль бус эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээ өсөн нэмэгдсэн, төрөл, зүйл олширсон, насанд хүрээгүй хүүхэд, идэр наасны залуучууд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаа нь сүүлийн жилүүдийн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харагдаж байна. Мөн манай улсын иргэд гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт бүлэглэлийн "өгөөш" болж, хар тамхины гэмт хэрэгт холбогдон олон жилийн хорих болон цаазаар авах ялаар шийтгүүлэх болсон. Дээрх нөхцөл байдлыг дүгнэж үзвэл манай улсад гэмт хэргийн сүлжээнээс зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үүсэх нөхцөл бий боллоо.

Нөгөө талаас энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байсан түүхэн уламжлал, туршлага, мэргэшсэн хүний нөөц байхгүй, хэрэг илрүүлэх болон мөрдөн шалгах,

хянан шийдвэрлэх ажлын туршлага дутмаг, мөн эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй, гэрч, хохирогчийг хамгаалах механизм төгс бүрдээгүй, шинжлэх ухааны дэвшилтэд технологи нэвтрээгүй, техник хэрэгслээр хангагдаагүй, эдийн засгийн боломж хязгаарлагдмал зэрэг хүчин зүйлүүд нь хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэнд нөлөөлж, энэ төрлийн гэмт хэргийг нуугдмал байх нөхцлийг бүрдүүлж байна.

Иймд мэргэшсэн мөрдөгчийг бий болгох, хар тамхитай тэмцэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангах, эрх зүйн орчинг сайжруулах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны бодит байдлыг цогц хэлбэрээр судлах онол, арга зүйн асуудлыг товч боловч нээн гаргахыг зорилоо.

Нэг. Улс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн үндсэн шинж

Хүн төрөлхтөн оршин тогтонохиын тулд дайн мөргөлдөөн, байгалийн гамшиг, халдварт өвчин зэрэг байнгын аюул сүйрэлтэй цаг үргэлж тэмцэж ирсэн хэдий ч энэ бүх аюул сүйрлийн учруулах хор уршиг, эрсдэлийг улс гүрэн бүхэн үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх хүчин зүйлд хамааруулдаг.

Нэгдсэн Үндэстний байгууллагаас ХХI зуунд дэлхийн улс орнуудын "Үндэсний аюулгүй байдал"-д нөлөөлж болох 6 төрлийн аюулыг тодорхойлж, стратегийн түвшинд онцгой анхаарахыг улс, үндэстнүүдэд зөвлөсөн. Энэ аюулд "...Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг"<sup>1</sup> орсон байна.

Дэлхийн улс орнуудын анхаарлыг хамгийн их татаж буй асуудлуудын нэг нь улс үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэрэг бөгөөд энэ гэмт хэрэг нь материал, санхүүгийн бааз суурьтай, гэмт байгууллагын уян хатан хөдөлгөөнт бүтэцтэй, хоёр ба түүнээс дээш улс орны нутаг дэвсгэрт үйлдэгдсэн эсвэл түүнийг бэлтгэх, төлөвлөх, хяналт тавих ажиллагаа нь өөр улсын нутаг дэвсгэрт явагдсан, түүний бодит хор уршиг, хохирол нь өөр улсын нутаг дэвсгэрт илэрсэн, мөн төрийн байгууллагатай авилгын холбоо сүлбээ тогтоосон зэрэг шинжийг агуулна. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд их хэмжээний хөрөнгө, мөнгө эзэмшин олон улсын хүрээнд үйл ажиллагаа явуулж, хууль бусаар асар их мөнгө олж, түүний эх үүсвэрийг нь нуун дарагдуулах, хууль ёсны болгож хувиргахын тулд мөнгө угаах гэмт хэргийг хавсран үйлдэж байдаг.

АНУ-ын Үндэсний Тагнуулын зөвлөлийн "2015 он хүртлэх хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлага" илтгэлд дурдсанаар: "Жилд хар тамхи наймаалдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэл 100-300 тэрбум ам.доллар, 10-12 тэрбум ам.долларыг хорт бодис болон химийн хог хаягдлаас, авлигаас 500 тэрбум ам.долларын ашиг олж байгаа нь дэлхийн үндэсний нийт бүтээгдэхүүний нэг хувьтай тэнцдэг" ба энэ тоо баримт нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн хор уршиг, эрсдэлийг тодорхой харуулж байгаа тоон үзүүлэлт юм.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 11 сарын 15-ны өдөр батлагдсан "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенци"<sup>2</sup>-д Монгол Улс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр нэгдэн орсноор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үргийг олон улсын өмнө хүлээсэн. Зохион байгуулалттай гэмт явдалтай амжилттай тэмцэх эрх зүйн зохицуулалт, суурь үндсийг Монгол Улсын Их хурлаас Эрүүгийн хуульд 1993 оны 6 дугаар сарын 7-нд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Эрүүгийн хуулийн түүхэнд зохион байгуулалттай гэмт

<sup>1</sup> Өнөөдөр сонин 2011-03-28 №073 "Тусгаар тогтол ба үндэсний аюулгүй байдал" ЯТА-ийн тэнхимиийн эрхлэгч, түүхийн ухааны доктор Ж.Бор

<sup>2</sup> Международно-правовые основы борьбы с коррупцией и отмыванием преступных доходов..., сборник документов..., Москва., ИНФРА-М, 2004, стр.7-45

хэргийн тухай хуульчилсан тодорхойлсон өгсөн явдал чухал ач холбогдолтой.

Одоо манай улсад Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газрын хоорондын 2011 оны 7 сарын 7-ны өдөр байгуулсан “Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” гэрээ, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, ОХУ-ын Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих холбооны албаны хооронд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” гэрээ, Монгол Улсын ХЗДХЯ, БНХАУ-ын НАХЯ-ны хар тамхитай тэмцэх газрын хооронд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай” санамж бичиг зэрэг эрх зүйн зохицуулалтын баримт бичигт олон улсын түвшинд хамтран ажиллах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар тусгасан байдаг.

Мөн Улсын Их хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аулгүй байдлын үзэл баримтлалын З дугаар бүлгийн 3.4.4.-т “Иргэдийг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс хамгаалагдах нөхцлийг сайжруулна, мөн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх, үндэсний чадавхийг бэхжүүлнэ” гэж тусгасан.

Зохион байгуулалттай гэмт явдалтай үр нөлөөтэй тэмцэхэд олон улсын зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн төрөл, үндсэн онцлог шинжүүдийг мэдэх асуудал онцгой чухал.

Хар тамхи, мансууруулах зүйлийн хууль бус худалдаа нь хамгийн их ашиг орлоготой бөгөөд улс үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн маш нарийвчилсан төрөлд багтдаг ба нэг ёсондоо “Наркобизнес”-ийн сүлжээ юм.

Оросын стратеги судалгаа, шинжилгээний баримт бичигт мансууруулах зүйлийн томоохон картелиуд мансууруулах зүйлийн бүхий л бизнесийн салаа мөчир бүрийг хяналтандаа оруулсан байдгийг цохон тэмдэглэсэн байна. Энэ нь мансууруулах зүйл агуулсан ургамлын тариалалт – байгалийн буюу синтетик мансууруулах зүйлийн үйлдвэрлэлт – контрабанд – борлуулалт – мансууруулах зүйлийн мөнгө угаалт<sup>3</sup> гэсэн үе шат, дамжлагаар явагддаг.

Тухайлбал, Колумбын мансууруулах зүйлийн картель<sup>4</sup> нь Европын мансууруулах зүйлийн хууль бус худалдааны зах зээлийг эзлэхийн тулд зохион байгуулалтын нарийн бүтцийг бий болгосон байдаг. Үүнд:

- Мансууруулах зүйлийг тээвэрлэх (усан хөлөг онгоц, нисэх онгоц түрээслэх, агаарын ба усан тээврээр зорчих үед мансууруулах зүйлийг зарлага буюу “курьер”-ээр дамжуулан илгээх) асуудлыг шийдвэрлэх.

- Мансууруулах зүйлийн нууц “агуулах” байгуулах.

- Борлуулах улсдаа байнга оршин суух өөрийн төлөөлөгчийг томилох.

- Мансууруулах зүйлийн үйл ажиллагааг далдан халхавчлах ажил хэргийн өдөр тутмын хууль ёсны хэлхээ холбоог тогтоох.

- Борлуулалтын сүлжээ бий болгох.

- Олсон орлогоо мөнгө угаах байдлаар “хууль ёсны бизнест оруулах”.

Судлаач, эрдэмтэд, практикийн ажилтнууд зохион байгуулалттай гэмт явдлын зүй тогтол, хөгжлийг дотроос нь хоёр гол чиглэлийг онцлон авч үзсэн байна.

Нэгдүгээрт: Улс орны эдийн засгийн үйл ажиллагаанд гэмт бүлэглэл шууд

<sup>3</sup> Основы борьбы с организованной преступностью..., “ИНФО-М”, Москва., 2006., стр 42.

<sup>4</sup> Б.Алтанбагана “Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг”. УБ, 2014, 98 дахь тал

оролцдог ба бизнесийн хүрээнийхэн болон үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийг хүчээр дарамталж ажил хэрэгт нь шууд бус оролцдог.

Хоёрдугаарт: Мансууруулах зүйл худалдаалах, валютын гэмт хэрэг үйлдэх, мөрийтэй тоглоомын үйлчилгээ эрхлэх, зэвсэг худалдаалах, захиалгат аллага үйлдэх, хүн барьцаалах зэрэг хориглосон үйл ажиллагааг эрхэлдэг.

Төрийн удирдлагын эрх мэдэл, улс орон дахь эдийн засгийн явцын хяналт руу зохион байгуулалттай гэмт явдал ямагт тэмүүлдэгийг олон улсын туршлага харуулж байна.

Хоёр. Монгол Улс дахь хар тамхины гэмт хэргийн нөхцөл байдал, онол практикийн асуудлууд

Өдрөөс өдөрт, улсаас улсад хүрээгээ тэлсээр буй хар тамхи гэгч хар мөртэй “Цагаан тахал”-тай тэмцэхийн тулд хүний эрхийг дээдэлсэн оновчтой бодлого гаргахыг Нэгдсэн үндэстний байгууллага болон хүний эрхийн байгууллагаас улс орнуудад уриалдаг.

Даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж байгаа энэ үед техник технологийн хөгжил дэвшил, мэдээллийн сүлжээний урсгал хязгааргүй тархаж, Монгол Улс нээлттэй болсноор гадаад, дотоодын иргэд хил гаалиар чөлөөтэй зорчих болсонтой холбоотой үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, үүнээс мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисийн хууль бус эргэлттэй холбогдсон гэмт хэргийн гаралт жил бүр өсөн нэмэгдэж, түүний арга, хэлбэрүүд байнга хувьсан өөрчлөгдж байна.

Монгол Улсын иргэд хар тамхины гэмт хэрэгт холбогдох, ялангуяа гадаад улсын нутаг дэвсгэрт олон жилийн хорих болон цаазаар авах ялаар шийтгүүлэх болсон нь судлаачдын анхаарлыг татсан асуудал бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг нь “кrimиналь” бизнес болон хувирч гэмт бүлэглэлүүд улс дамнасан сүлжээ, тогтолцоог үүсгэн эрчимтэй ажилласнаар хэрэглэгч, донтогчдын хүрээ ихсэж, гэмт үйл ажиллагаагаа идэвхжүүлсээр байгаа билээ.

НҮБ-ын Хар тамхины гэмт хэрэгтэй тэмцэх албаны 2012 оны тайланд: Дэлхийн улс орнуудын 15-64 насны 230 сая хүн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж байгаагаас 27 сая орчим нь тогтмол хэрэглэдэг. Үүнээс 200 орчим сая хүн каннабис, 15 орчим сая хүн амфетамин, 15.9 сая хүн опиум (героин), 13.7 сая хүн кокаиныг хэрэглэж болгосон байна. Түүнчлэн 16 сая хүн судсаар хар тамхи хэрэглэж байгаагийн 3 сая орчим нь ХДХВ (ДОХ)-ын вирустэй гэсэн судалгаа гаргасан байна.

Дэлхийд хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн сүлжээ үүсгэн идэвхтэй ажиллаж байгаа Алтан турвалжин (Тайланд, Лаос, Мьянмарын хилийн бүс), Алтан хавирган сар (Афганистан, Пакистан, Ираны хилийн бүс), Хар турвалжин (Нигер, Гана, Кени, Судан, Өмнөд Африк) гэх Африкийн орнуудын гэмт бүлэглэлүүд нь Төв болон Зүүн өмнөд Азийн орнуудын иргэдийг хар тамхины хууль бус наймаанд элсүүлэх, татан оролцуулах, тээвэрлүүлэх явдал газар авч байна.

Ялангуяа Зүүн өмнөд Азийн орнуудад сурч буй манай оюутан залуус, биеэ үнэлэгчид, хулгай хийх зорилгоор маршрутаар зорчигч иргэд энэ төрлийн гэмт хэрэгт тээвэрлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгт монгол залуучууд өртөж байгаа шалтгаан нь манай иргэдийн амьжирагааны

түвшин доогуур, энэ талын мэдлэг, мэдээлэл дутмаг, амар хялбар аргаар мөнгө олох хүсэлтэйгээс гадна Зүүн өмнөд Азийн 30 гаруй оронд визгүй зорчдог байдал нь гол хүчин зүйл болж байна.

Манай улсын иргэдийг брэнд бараа зөвлгөх нэрийдлээр хууран мэхлэх, авч яваа ачаа тээшин дотор хар тамхи нуух, хар тамхи тээвэрлэж байгааг мэдэгдүүлэхгүй байх, их хэмжээний шан харамж амлах, гадаадын гэмт бүлэглэлээс интернет, сайт ашиглан бизнес санал тавих, өөрийн оршин суугаа улс, оронд айлчлахыг урих, зочид буудалд байрлах болон ирж, буцах онгоцны зардлыг хариуцах гэх зэргээр итгэлийг нь олох аргаар элсүүлэлт хийж, гэмт хэргийн "өгөөш" болгож байна.

Мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус нийлүүлэлт Монгол Улсад З замаар явагдаж байгаа бөгөөд хил залгаа БНХАУ, ОХУ болон зүүн өмнөд Азийн улс орнуудаас кокайн, героин, синтетик бодисуудыг хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зарж борлуулах, дамжин өнгөрүүлэх байдлаар, нөгөө тал нь манай орны нутаг дэвсгэрт 9 төрлийн мансууруулах бодис агуулсан ургамал их хэмжээгээр ургаж байгаа нь хүүхэд, залуучуудын дунд түүж, боловсруулах нэхцлийг бүрдүүлж, энэ төрлийн бодисны нийлүүлэлтийн гол эх сурвалж нь болсон юм.

Олон улсын жишгээр дамжин өнгөрч буй хар тамхины 20 хувь нь тухайн оронд үлддэг гэсэн судалгаа байдаг бөгөөд одоогийн байдлаар манай улсын нутаг дэвсгэрээр хэдий хэмжээний мансууруулах үйлчилгээтэй эм, бэлдмэл, бодис дамжин өнгөрч байгааг нарийн тогтоох боломжгүй байна.

Манай улс мансууруулах бодисуудын тухай 1961 оны конвенцид 1990 онд, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн үндэстний байгууллагын 1988 оны конвенцид 2001 онд тус тус нэгдэн орсон.

Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор холбогдох хууль, дүрэм, журам, стандартууд гарган мөрдөж байгаа ч нөхцөл байдлын хурдацтай өөрчлөлтийн улмаас асуудлыг бүрэн дүүрэн зохицуулахад дутагдалтай байна.

Төрийн болон төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаагаар манай улсад мансууруулах эм, бодисын буруу хэрэглээ өсөх хандлагатай байна. Тухайлбал:

- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн статистикийн мэдээллээр сэтгэцэд нөлөөт эм болон бусад бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд 1999 онд 10.000 хүнд 7.5 байсан бол 2008 онд 14.1 болж нэмэгдсэн байна.

- Мөн Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын өсвөр насныхны дунд хар тамхи, мансууруулах бодисын хэрэглэгчдийн тоо жил ирэх тутам өссөөр байна.

- Сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглэгчид зөвхөн татаж хэрэглэдэг байсан бол сүүлийн жилүүдэд судсаар тарьж хэрэглэх болсон нь ХДХВ-ийн халдвартархах эрсдэл ихтэй анхаарал татсан асуудал болоод байна.

2002-2009 оны хооронд 8 жилийн хугацаанд 63 гэмт хэрэгт 184 хүн, 2010-2014 оны хооронд 179 гэмт хэрэгт 598 хүн холбогдон шалгагдсан байна. Энэ нь 1 жилд дунджаар 35.8 гэмт хэрэгт 119 хүн холбогдон шалгагдсныг 2002-2009 оны дундаж тоон үзүүлэлттэй харьцуулахад гэмт хэрэг 4.5 дахин, холбогдогч 5.1 дахин өссөн байна.

2015 оны эхний хагас жилийн байдлаар 25 хэрэгт 60 хүн холбогдон шалгагдаж байна.

Гэмт хэрэгт холбогдогчдын 69.2 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, дийлэнх

нь 18-35 насны залуучууд байна. Олон улсын жишгээр нэг хэргийн ард 10 тохиолдол байдаг гэж үзвэл Монгол Улсын мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал хүндрэх төлөв ажиглагдаж байна.

Хөрш зэргэлдээ орнуудын энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал нь манайд сөргөөр нөлөөлж, хууль бус наймаа эрхэлдэг гэмт бүлэглэл нь тус улсын нутаг дэвсгэрээр мансууруулах бодис болон түүний түүхий эдийг дамжин өнгөрүүлэх, Монгол Улсад өөрийн зах зээлтэй болох оролдлого хийж болзошгүй байна.

2010 онд Нийслэлийн гэмт хэргээс урдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хийсэн "Нийслэлийн өсвөр үе, залуучуудын дунд мансууруулах сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодисын хэрэглээ, ойлголтын талаарх тандалт судалгаа"-нд нийслэлийн нийт 2000 өсвөр насны хүүхэд, залуучууд хамрагдсан ба судалгаагаар:

1. Өсвөр үеийнхэний дунд архи, тамхины хэрэглээ өндөр байгаа ба бусад төрлийн мансууруулах эм бодисыг тодорхой хэмжээгээр хэрэглэдэг гэсэн байна. Тодруулбал: Нийт судалгаанд хамрагдагсдын 44,6% архи, 40,3% тамхи, 2,9% бензин, цавуу, 1,8% (36) каннабис, 0,9% (18) экстази хэрэглэж үзсэн. Түүнийг сорох, татах, уух, үнэрлэх, тарих зэргээр хэрэглэдэг гэжээ.

2. Каннабис, экстази хэрэглэж үзсэн нийт 54 буюу 2,7% хүүхэд байсны 74,4% нь их, дээд сургууль, коллежийн оюутнууд, 25,6% нь Ерөнхий Боловсролын сургуулийн сурагчид байна. Ерөнхий боловсролын сургуулиудаас 91,7% нь хотын төвийн сургуулийн хүүхдүүд байсан байна.

3. Мөн каннабис, экстази хэрэглэж үзсэн гэх 54 оюутан сурагчдаас 52 буюу 96% нь 24 хүртэлх насныхан байна.

4. Нийт судалгаанд оролцогч 436 оюутан сурагчдад мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэж үзэх талаар санал ирж байсан.

5. Энэхүү судалгааны дүнг нийслэлийн нийт 1.106.719 хүн (2009 оны статистик тоо) амтай харьцуулахад 100.000 хүн ам тутмын 2700 нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг ба түүнийг хэрэглэх санал 21800 хүнд ирж байсан байх магадлалтай гэсэн тооцоолол гарч байна.

6. Эдгээрийн 49% нь өдөрт 1 удаа, 39% 2-3 удаа, 6% 4-5 удаа, 6% нь түүнээс дээш давтамжтайгаар тус тус хэрэглэдэг. Түүнчлэн 19% нь тухайн бодисыг үгүйлдэг, 19% нь ганцаараа хэрэглэдэг нь манай улсад мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодисын хэрэглээ жил ирэх бүр нэмэгдэж, нэр төрөл нь олширч байгааг нотлохын сацуу донтох эмгэгт өртөх болсныг харуулж байна.

Тиймээс энэ төрлийг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах гэсэн нэгдмэл зорилго нь улс орнуудыг олон улс, бус нутаг болон үндэсний хэмжээнд тэмцэх зайлшгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын нэг цагдаагийн байгууллага нь энэ төрлийн гэмт хэргийг гүйцэтгэх ажлын хүч, арга, хэрэгслээр урьдчилан сэргийлэх, илрүүлэх, нотлох баримтыг бүрдүүлэх, түүнчлэн бие даасан алба, мэргэшсэн "мөрдөгч"-ийг бий болгох, тэднийг мэргэжлийн удирдлагаар хангах, энэ чиглэлээр эрдэмтэн судлаачдаар дагнасан судалгааны ажлыг хийлгэх, хууль эрх зүйн орчинг сайжруулах зэрэг асуудлыг стратегийн түвшинд шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн 29 дэх заалтад тусгасан зорилтын дагуу Цагдаагийн байгууллагын тухай хууль, Төсвийн

байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль бусад хууль тогтоомж, төслийн хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн боловч "Гэмт хэргийн өсөлт, цагдаагийн албан хаагчдын ажлын ачаалал, гэмт хэрэг илрүүлэхэд ашиглагдаж буй техник хэрэгсэл, технологийн дэвшил нь гэмт хэрэгтэй тэмцэхэд хангалтгүй байна. Иймд цагдаагийн байгууллагад өндөр ур чадвартай алба хаагч, хүчин чадал сайтай техник хэрэгсэл шаардлагатай"<sup>5</sup> байгааг онцлон тэмдэглэсэн.

Иймд цагдаагийн байгууллагын хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцдэг албанад орчин үеийн дэвшилтэд техник технологи, багаж хэрэгслийг нэвтрүүлэх зорилгоор ОХУ-ын Мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих холбооны албаны мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор ашигладаг, 5-10 минутын хугацаанд хар тамхи хэрэглэсэн эсэхийг тогтоодог "Имедис" нэртэй аппаратыг манай улс практик үйл ажиллагаанд ашиглах хэрэгцээ байна. "Имедис" аппарат нь компьютерт програмчлагдсан мансууруулах төрлийн бодисын мэдээллийг ашиглан хүний био давтамжаар тодорхойлдог. Энэ аппаратыг ажиллуулахад зэөврийн компьютер (notebook) шаардлагатай, хэрэглээний программын мэдлэгтэй хүн ажиллуулах бүрэн боломжтой бөгөөд үнэний магадлал нь 98 хувьтай байдаг. Уг аппарат нь 150.000 рубль буюу ойролцоогоор 5000 ам.долларын үнэтэй бүтээгдэхүүн байна. Энэ аппаратыг Хууль зүйн яамаар дамжуулан холбогдох газарт санал хургуулэн практик үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглах санал дэвшүүлж байна.

## Дүгнэлт

1. Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодисын хууль бус эргэлттэй холбоотой цогц асуудлыг багтаасан хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох хариуцлагын тогтолцоог чангатгах;

2. Мансууруулах бодистой тэмцэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах;

3. Хар тамхитай тэмцдэг байгууллагуудын туршлага судлах;

4. Мансууруулах болон сэтгэц идэвхт эм, бодисын хэрэглээ, эрсдэлт зан үйлийг тодорхойлох "Үндэсний хэмжээний тандалт судалгаа"-г тодорхой давтамжтайгаар явуулах;

5. Мэргэшсэн алба, хүний нөөц бий болгох, эрдэмтэн судлаачдаар дагнасан судалгаа хийлгэх болон энэ төрлийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр онол, арга зүйг боловсруулах зэрэг хэрэгцээ, шаардлага Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын өмнө тулгарч байна.

## Эх сурвалжийн жагсаалт.

1. Монгол Улсын их хурлын 2010 оны 48 дугаар тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.

2. Ж.Амарсанаа. Монгол Улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл. УБ., 2010 он

3. "Өнөөдөр" сонин. 2011.03.28. №73 "Тусгаар тогтнол ба үндэсний аюулгүй байдал". Үндэсний тагнуулын академийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D) Ж.Бор.

4. Тусгаар тогтнол сэтгүүл. 2012 он дугаар № 03

5. Ж.Болд. Хар тамхитай холбоотой гэмт хэргийг шалгахад анхаарах зарим асуудал. УБ., 2013 он

6. Н.Мөнхзүл. Хар тамхи. УБ., 2013 он

7. Б.Алтанбагана "Улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг" УБ., 2014.

<sup>5</sup> "Монгол улсын шүүх эрх мэдлийн шинэтгэл" судалгааны тайлан. УБ., 2010, 109 дэх тал.

8. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ., 2014 он
9. Ж.Мөнхболд. Манзууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал. УБ., 2015 он
10. Междунароно-правовые основы борьбы с коррупцией и отмыванием преступных доходов..., сборник документов..., Москва., ИНФРА-М, 2004
11. А.А.Зарубен, В.А.Иванина. Противодействие легализации преступных доходов от незаконного оборота наркотиков органами наркоконтроля. Хабаровск., 2005 г.
12. Основы борьбы с организованной преступностью...," ИНФО-М., Москва., 2006